



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 28 өдөр

Дугаар A/157

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын цахим хуудас ажиллуулах, мэдээлэл байршуулах, түгээх, ашиглах журмыг хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Хонгорзул)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.АЛТАНЦЭЦЭГ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын 2026 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
4/157 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЦАХИМ ХУУДАС АЖИЛЛУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ, ТҮГЭЭХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын (цаашид “Газар” гэх) цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл бэлтгэх, хянах, байршуулах, түгээх, шинэчлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг Газрын цахим хуудсанд мэдээлэл бэлтгэх, хянах, нийтлэх, техникийн үйлчилгээ үзүүлэхэд оролцож буй албан хаагч дагаж мөрдөнө.

1.3. Цахим хуудсаар мэдээлэл түгээхдээ үнэн зөв, шуурхай, ойлгомжтой, хүртээмжтэй, хууль тогтоомжид нийцсэн, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байх зарчмыг баримтална.

Хоёр. Мэдээлэл бэлтгэх, хянах, байршуулах

2.1. Цахим хуудсанд нийтлэх мэдээллийг холбогдох нэгж, албан хаагч бэлтгэж, агуулгын үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.2. Мэдээллийг нийтлэхийн өмнө холбогдох нэгжийн удирдлага, шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хянан баталгаажуулна.

2.3. Цахим хуудас хариуцсан албан хаагч нь баталгаажсан мэдээллийг тогтоосон ангилал, бүтэц, хэлбэрээр байршуулж, нийтлэгдсэн мэдээллийн харагдах байдал, холбоос, хавсралтын ажиллагааг шалгана.

2.4. Мэдээлэл нийтлэхдээ зохиогчийн эрх, оюуны өмчийн эрх болон холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Гурав. Мэдээлэл түгээх, шинэчлэх

3.1. Цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээллийг шаардлагатай тохиолдолд Газрын албан ёсны нийгмийн сүлжээ болон бусад зөвшөөрөгдсөн цахим сувгаар түгээнэ.

3.2. Цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд алдаа илэрсэн, эсхүл агуулга нь шинэчлэгдсэн тохиолдолд эрх бүхий албан хаагч нэн даруй засварлаж, шинэчилнэ.

3.3. Хууль тогтоомж, шийдвэр, журам өөрчлөгдсөн тохиолдолд цахим хуудсанд байршуулсан холбогдох мэдээллийг шинэчилж, шаардлагатай тохиолдолд өмнөх мэдээллийг архивлана.

Дөрөв. Цахим хуудасны аюулгүй байдал

4.1. Цахим хуудасны удирдлагын эрх, хэрэглэгчийн нэр, нууц үгийг зөвшөөрөлгүй этгээдэд дамжуулах, бусдад ашиглуулахыг хориглоно.

4.2. Албан хаагчийн ажил үүрэг өөрчлөгдөх, чөлөөлөгдөх тохиолдолд түүнд олгосон цахим хуудасны эрхийг байгууллагын дотоод сүлжээний асуудал хариуцсан инженер тухай бүр цуцлах буюу өөрчилнө

4.3. Цахим хуудасны хэвийн ажиллагаа, техникийн шинэчлэл, хамгаалалтын тохиргоог мэдээллийн технологи хариуцсан инженер хариуцна.

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн, зөвшөөрөлгүй мэдээлэл нийтэлсэн, мэдээллийг санаатайгаар өөрчилсөн, устгасан, эсхүл мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомж болон байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгын үнэн зөв байдлыг мэдээллийг боловсруулж, баталгаажуулсан нэгж, албан хаагч хариуцна.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү журмаар зохицуулаагүй асуудлыг холбогдох хууль тогтоомж болон Газрын бусад дотоод журмыг баримтлан шийдвэрлэнэ.

6.2. Журмыг хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагаа, технологийн өөрчлөлттэй уялдуулан шаардлагатай тухай бүр шинэчилнэ.